

МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЧЛОЛ

№ 15/1

Улаанбаатар хот

Мөнгөний бодлогын зөвлөл (МБЗ) нь 2014 оны 11 дүгээр сарын 27, 2015 оны 1 дүгээр сарын 12, 14-ний өдрүүдэд нийт 3 удаа хуралдсан бөгөөд хурлыг Монголбанкны Ерөнхийлөгч Н.Золжаргал удирдан явуулав.

2014 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр МБЗ нь Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газар (МБСГ)-аас танилцуулсан макро эдийн засгийн өнөөгийн болон ойрын ирээдүйн төлөв, бодлогын шийдвэрийн хэд хэдэн хувилбар, тэдгээрийн үр дагаврын талаарх дараах асуудлуудыг авч хэлэлцэв.

Америкийн Нэгдсэн Улсын эдийн засгийн өсөлт 2015-16 онуудад тогтворжихоор байгаа хэдий ч Европын холбооны эдийн засаг төдийлөн сэргэхээргүй байна. Түүнчлэн Хятадын засгийн газар зээл олголтыг хумих, үргүй зардлыг бууруулах замаар илүү тэнцвэртэй, нам тогтвортой өсөлтөд чиглэсэн бодлого явуулснаар эдийн засгийн өсөлт нь аажмаар саарч байна. Ойрын хугацаанд экспортын гол нэрийн барааны үнэ өсөх хандлага харагдахгүй, төлбөрийн тэнцлийн хүндрэлийг засах боломж олгохооргүй байгаа тул 2017 оноос эхлэн төлөгдөх гадаад өрийн асуудлыг шийдэх арга замыг одооноос төлөвлөх шаардлагатай юм. Үүний тулд макро эдийн засгийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх зорилгоор гадаад, дотоод эдийн засгийн тэнцвэрийг дэмжих, инфляцийг зорилтот түвшинд байлгах, банкны салбарын дархлааг сайжруулах арга хэмжээнүүдийг одооноос авч, ирээдүйн өндөр хүүний дарамтаас сэргийлэх шаардлагатай байна.

2015 онд гадаад эрэлт сэргэх төлөвгүй, өрхийн өр, орлогын харьцаагаар хязгаарлагдсан хувийн хэрэглээ дорвитой өсөхгүй, 2015 оны батлагдсан төсвийн орлогыг өөдрөгөөр төсөөлсөн нь орлого тасрах эрсдэлийг дагуулж төсвийн зардал, тэр дундаа хөрөнгө оруулалтыг бууруулахаар байна. Дээрх шалтгаануудын улмаас эдийн засгийн өсөлт төдийлөн нэмэгдэхгүй бөгөөд оны эцэст 5.7% гарахаар төсөөлж байна.

Инфляцийн суурь төсөөллөөр 2015 онд эрэлтийн гаралтай инфляцийн дарамт бага байх бөгөөд оны эцэст инфляци 8.1% гарах төлөвтэй байна. Гэхдээ инфляцийг эрчимжүүлэхгүй байлгах, суурь инфляцийг бууруулах шаардлага хэвээр байна.

Төлбөрийн тэнцлийн урсгал данс алдагдалтай хэвээр, түүнийг нөхөх хэмжээний ашиг хөрөнгө санхүүгийн данснаас бий болохооргүй байгаа нь оны эцэст төлбөрийн тэнцэл алдагдалтай хэвээр, гадаад валютын нөөцөд дарамт үзүүлэхээр байна.

Энэхүү хурлаар инфляци, төгрөгийн ханш, эдийн засгийн бодит өсөлтийн богино хугацааны төсөөллийг Төв банкны хэрэгжүүлж буй уламжлалт болон уламжлалт бус мөнгөний бодлогын хүрээнд хэд хэдэн хувилбараар хийж танилцуулсан. Энэ нь МБЗ-ийн гишүүдэд бодлогын нөлөө, үр дүнг харьцуулан дүгнэлт хийх боломж олгох юм.

МБСГ-ын зүгээс 2015 оны эцэст инфляцийг зорилтот 7%-ийн түвшинд байлгах, макро эдийн засаг болон санхүүгийн тогтвортой байдлыг дунд хугацаанд бий болгох үүднээс Бодлогын хүүг нэг нэгж хувиар өсгөх, мөн уламжлалт бус мөнгөний тэлэх бодлогыг үе шаттай хумих саналыг хурлаар танилцуулсан. МБЗ-ийн ажиллах журмын дагуу

Монголбанкны Ерөнхийлөгч мөнгөний бодлогын саналыг шүүмжлэх болон хамгаалах багийг тус тус томилсон болно.

МБЗ-ийн 2015 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн хурлаар Бодлогын саналтай холбоотой хэд хэдэн асуудлаар шүүмжлэх баг байр сууриа илэрхийлсэн бол хамгаалах баг холбогдох тайлбарыг хийх байдлаар хэлэлцүүлэг өрнөлөө.

Шүүмжлэх баг юуны түрүүнд мөнгөний бодлогын уламжлалт бус арга хэрэгсэл буюу тусгайлсан хөтөлбөрүүдийн хүрээнд мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлсэн тохиолдолд мөнгөний бодлогын хүүг өөрчлөх нь үр дүнгүй болохыг илэрхийлсэн. Хоёр багийн хувьд уламжлалт бус мөнгөний тэлэх бодлогоос үе шаттайгаар гарах нь зүйтэй гэдэгт санал нэгдэж байлаа.

Эдийн засгийн идэвхжил эрс суларсан, инфляцийн түвшин, мөнгө, зээлийн үзүүлэлтүүдийн өсөлт саарсан одоо үед Бодлогын хүүг өсгөх нь банкны системд эрсдэл бий болгох, улмаар эдийн засгийн хямралд хүргэж болзошгүйг шүүмжлэх багийн зүгээс анхааруулж байлаа. Угтаа бол ийм үед төсөв, мөнгөний тэлэх бодлогыг хэрэгжүүлэх ёстой. Харамсалтай нь төсвийн орлого эдийн засгаа дагаад хумигдаж байгаа үед төсвийн зардлыг нэмэгдүүлэн, тэлэх бодлого хэрэгжүүлэх боломж бага байна. Нөгөө талаасаа мөнгөний бодлогыг хатууруулах нь угаасаа агшиж буй эдийн засгийг улам унагаах нөлөөтэй. Өөрөөр хэлбэл бодлогын орон зай маш хумигдмал ийм нөхцөлд хүүг өсгөх нь эерэг гэхээсээ илүү сөрөг үр дүнд хүргэж магадгүй. Эдийн засаг 2015 онд хумигдахын хэрээр инфляцийн дарамт багасна. Тэг инфляци, эсвэл бүр дефляци бол амьдрал байхгүй газарт л байдаг зүйл, тодорхой түвшин хүртэл инфляциас айгаад байх зүйлгүй гэсэн байр суурийг ч илэрхийлж байв. Мөнгөний бодлогыг дараагийн 1 жил, жил хагасын цар хүрээтэй нь уялдуулан авч үзэх нь зүйтэй гэлээ.

Хамгаалах багаас Монголбанкны мандатад анхаарлаа хандуулахыг хүсэв. Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд Төв банкны үндсэн зорилтыг тов тодорхой буюу инфляци хэмээн заасан байгаа. Эдийн засгийн өсөлт, санхүүгийн тогтвортой байдал зэрэг нь Монголбанкны хувьд хоёрдогч зорилтууд байдаг, анхдагч зорилт болох үнийн тогтвортой байдалд захирагдсан зорилтууд гэж ойлгох ёстойг онцолж байв. Хэдийгээр инфляцийн түвшин буурч байгаа ч гэсэн суурь инфляци өндөр хэвээр байна. Бодлогын хүүг өсгөснөөр инфляцийн хүлээлтийг хазаарлах, инфляци дахь ханшийн нөлөөллийг бууруулахад тодорхой эерэг нөлөө үзүүлнэ. Нөгөө талаас макро бодлогын цогц өөрчлөлтийг нэгдсэн байдлаар хийж байна гэсэн эерэг дохиог хөрөнгө оруулагчдад өгнө. Гадаадын шууд хөрөнгө оруулалт улам муудсан, төлбөрийн тэнцэл алдагдал хүлээсэн хэвээр байгаа үед түүний эсрэг мөнгөний бодлогын зөв дохиог зах зээлд өгөх, хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээх, валютын урсгалыг нэмэгдүүлэх, төгрөгийн өгөөжийг өсгөхийн тулд бодлогын хүүгээ нэмэх нь зүйтэй юм. Чухам ийм зөв зүйтэй шийдвэрийг цаг алдалгүй гаргахын тулд л МБЗ-ийг байгуулсан гэж ойлгож болно гэх зэрэг байр суурийг илэрхийлэв.

Ийнхүү МБЗ-ийн гишүүд мөнгөний бодлогын саналыг тал бүрээс нь авч үзэн, өргөн хүрээнд хэлэлцүүлэг хийсний дүнд инфляцийн түвшин 2014 оны эцэст 11.0 хувьд хүрч буурсан хэдий ч, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн өөрчлөлт болон төрийн зохицуулалттай үнийн өсөлтийн нөлөөгөөр суурь инфляци 12.6 хувь буюу өндөр хэвээр байгаа, эдийн засагт орж ирэх гадаад валютын урсгал сэргээгүй, гадаадын шууд хөрөнгө

оруулалт 3 дахь жилдээ дараалан муудсан нь Бодлогын хүүг өсгөх нөхцөлийг бүрдүүлж байна гэсэн зарчмын байр суурьт санал нэгдлээ. Хурлыг удирдагч бодлогын хүүг 1 нэгж хувиар өсгөх талаар санал хураахад МБЗ-ийн олонх гишүүд дэмжсэнээр бодлогын хүүг 1 нэгж хувиар өсгөхөөр тогтов.

Бодлогын хүүг өсгөснөөр богино хугацаанд нийт эрэлт, урсгал тэнцлийн алдагдлыг бууруулах, инфляцийг нам, тогтвортой түвшинд байлгах, санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдлыг дэмжихэд эергээр нөлөөлнө гэдэгт зөвлөлийн гишүүд санал нэгдсэнээр МБЗ-ийн хурал өндөрлөв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Монголбанкны МБЗ-ийн 2015 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн хурлаар Бодлогын хүүг 1.0 нэгж хувиар нэмэгдүүлж, 13.0 хувь болгох шийдвэр гаргав.